



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 0/17

Улаанбаатар хот

Хаврын ээлжит техникийн хяналтын
үзлэг, оношилгоо зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын Дүрэм -ийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний их, дунд, бага багтаамжийн автобус, троллейбус, ажилчдын автобус болон такси үйлчилгээний тээврийн хэрэгслийн хаврын ээлжит Техникийн хяналтын үзлэг, оношилгоог 2019 оны 03 дугаар сарын 25-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж, үзлэг оношилгоонд орох хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн шуурхай зохион байгуулж, батлагдсан хугацаанд үзлэгт хамрагдаагүй болон тэнцээгүй тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг Улаанбаатар смарт карт ХХК-ийн Тbox програмд тухай бүрт нь оруулах, тэнцээгүй тээврийн хэрэгслийг тухайн өдөрт нь давтан оруулахгүй байх, үзлэгийн дүн мэдээг холбогдох байгууллага хэлтсүүдэд шуурхай, үнэн зөв хүргүүлж ажиллан, Захиргааны зөвлөлийн хуралд 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн дотор танилцуулах, холбогдох байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллахыг Техникийн хяналтын үзлэг, оношилгооны төв /Ц.Нанжид/-д даалгасугай.


3. Хаврын техникийн хяналтын үзлэг, оношилгоонд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх гэрээтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад тээврийн хэрэгслүүдийг баталсан хуваарийн дагуу шуурхай хамруулж хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /З.Цэвээндорж/-т үүрэг болгосугай.

4. Нийтийн тээврийн бүртгэлийн санд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг тушаалаар батлагдсан хуваарьт хугацаанд багтаан холбогдох стандартын шаардлагуудыг бүрэн хангуулж, тээврийн хэрэгслийн өнгө үзэмж, цэвэрлэгээ, иж бүрдэл, замналын нэр, хаяг, зураглал, дугаар зэрэг нэмэлт шаардлагуудыг онцгой

анхаарч техникийн хяналтын үзлэгт жигд, шуурхай хамруулахыг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг орлогч дарга /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР